



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/438

Арвайхээр

**Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,
тендер хүчингүй болгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3, 30 дугаар зүйлийн 30.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 71 дүгээр дүгнэлтийн дагуу Боловсрол, соёл, спортын салбарын их засвар, тоног төхөөрөмж /Өвөрхангай, Хархорин, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Уянга сум/ ажлын 1 дүгээр багц Хархорин сумын ЕБС-ийн 2 дугаар сургуулийн засварыг 108805848 (нэг зуун найман сая найман зуун таван мянга найман зуун дөчин найм), 3 дугаар багц Хархорин сумын 5 цэцэрлэгийн засварыг 58262498 (тавин найман сая хоёр зуун жаран хоёр мянга дөрвөн зуун ерэн найм), 10 дугаар багц Уянга сумын Жаргалант багийн цэцэрлэгийн өргөтгөл /Урлаг заалтай/ ажлыг 19996800 (арван есөн сая есөн зуун ерэн зургаан мянга найман зуу) төгрөгөөр Чусан ХХК-иар, 2 дугаар багц Хархорин сумын 4 цэцэрлэгийн засварыг 55001924 (тавин таван сая нэг мянга есөн зуун хорин дөрөв) төгрөгөөр Хархорин ус суваг ХХК-иар, 4 дүгээр багц Хархорин сумын Хөлбөмбөгийн талбай-2 ажлыг 336089666 (гурван зуун гучин зургаан сая наян есөн мянга зургаан зуун жаран зургаа) төгрөгөөр Смарт зоос ХХК-иар, 5 дугаар багц Хужирт сумын Хөлбөмбөгийн талбай ажлыг 168050196 (нэг зуун жаран найман сая тавин мянга нэг зуун ерэн зургаа), 14 дүгээр багц Зүүнбаян-Улаан сумын ЕБС-ийн засварыг 98751078 (ерэн найман сая долоон зуун тавин нэгэн мянга далан найм) төгрөгөөр Хөхмонгол групп ХХК-иар 6 дугаар багц Хужирт сумын 1 дүгээр цэцэрлэгийн засварыг 62990000 (жаран хоёр сая есөн зуун ерэн мянга) төгрөгөөр Гүнчимэгтэй ХХК-иар 7 дугаар багц Хужирт сумын 2 дугаар цэцэрлэгийн засварыг 52800000 (тавин хоёр сая найман зуун мянга) төгрөгөөр Сод-Ээл ХХК-иар, 8 дугаар багц Уянга сумын Жаргалант багийн сургуулийн дотуур байрны засварыг 106472528 (нэг зуун зургаан сая дөрвөн зуун далан хоёр мянга таван зуун хорин найм) төгрөгөөр Идум ХХК-иар, 9 дүгээр багц Уянга сумын Жаргалант багийн Соёлын төвийн засварыг 10000000 (арван сая) төгрөгөөр Оазислэнд констракшн ХХК-иар, 12 дугаар багц Уянга сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн гадна пассадны засварыг 30000000 (гучин сая) төгрөгөөр Химон констракшн ХХК-иар 15 дугаар багц ЕБС, цэцэрлэг, Соёлын төвийн тоног төхөөрөмжийг 286418781 (хоёр зуун наян зургаан сая дөрвөн зуун арван найман мянга долоон зуун наян нэг) төгрөгөөр Йи Би Си ХХК-иар тус тус гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

011100783

D:My Doc. Zahiramj. Zasag darga

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол) нарт тус тус даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгжүүд санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д үүрэг болгосугай.

4. Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй 11 дүгээр багц Уянга сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн гадна пассадны засвар, 13 дугаар багц Уянга сумын цэцэрлэгийн цэвэр усны шугамын гадна холболт зэрэг багцуудыг хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцуудыг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД